

7-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР

А хувилбар

Хугацаа: 60 минут

Нийт 20 оноо

Хотын хүүгийн шинэ явдал

Хотын байдал шалдар булдар цагийн эргэлт ороо бусгаа, энтээ уулын хөтлөөс тэртээ уулын хаяа хүртэл хар давхархайн зам зурайж, гэр хорооллын цагаан утаа үйлдвэрийн яндангийн хар утаатай давхарлан хөх тэнгэрт хөшиглөнө. Энд тэнд зам хөндлөн шуудуу ухаж шороо овоолсон байх бөгөөд тарьсан модыг үхэр шөргөөж, ямаа зулгана. Зуны лүгхийм халуунд асфальт хайлуулан хиншүү ханхалж түг түмэн машины өмхий утаа хамар цоргино.

Байшингуудын хаяагаар хог, цаас, тамхины иш хөглөрөн хааяа энд тэнд элсэн дээр бор жаал тоглон сууна. Хөлд орохоос аваад үс цайхыг хүртэл нэгэн гудамж өгсөн уруудан таварч, нэгэн дэлгүүрийн эргэн тойрон очёрлосоор энэхүү ертөнцийг эцэслэнэ. Суртал нэвтрүүлэгч Жамбал өөрчлөн байгуулалт гэж онож будилж ярих ба секторын эрхлэгч сэдэвт ажил гэж яршиг удахыг сонссоор өдөр сарыг улируулна.

Орбитоос цааш газаргүй хэмээн бодож, Оросуудаас дээш эрдэмтэнгүй гэж сэтгэсээр түмэн хэргээс хоцорч дэлхийн боловсролоос гээгдэнэ. Өглөө шугамын радио сонсож, үдэш телевизор шагайсаар нэгэн насыг хүний заавраар барна...

/Д.Ц “Хуучин хүүгийн шинэ явдал” өгүүллэгээс /

1. Эхээс хэрэг явдал болж байгаа газар орон, хүний үйл хөдлөл, гол дүрийн дотоод шинж төрхийг дүрсэлсэн хэсгийг олж бичээрэй. (2 оноо)
2. “Зуны лүгхийм халуунд асфальт хайлуулан хиншүү ханхалж түг түмэн машины өмхий утаа хамар нэвт цоргино. Өглөө шугамын радио сонсож, үдэш телевизор шагайсаар нэгэн насыг хүний заавраар барна... “гэсэн эхийн хэсгээс дараах үгсийн аймгийн 2 жишээг ялган бичээрэй. (2оноо)

Тэмдэг нэр:

Дуурайх, дүрслэх үг:

3. Эхээс ЗНӨ-ийг ялгаж бичээд, холбогдсон аргыг тодорхойлоорой. (2 оноо)

-
4. “Орбитоос цааш газаргүй хэмээн бодож, Оросуудаас дээш эрдэмтэнгүй гэж сэтгэсээр түмэн хэргээс хоцорч дэлхийн боловсролоос гээгдэнэ” гэсэн өгүүллэрийн тодруулсан бүтээврийн оронд тохирох бүтээврийг бичээрэй. 2 оноо
 5. Бусдаасаа өөр бүтэц бүхий үгийг сонгоорой. 2 оноо
А. хоцорч Б. гарч В. гэрч Г. авч
 6. Галигаас үндэсний бичигт хөрвүүлээрэй. (5 оноо)
Хүмүн- эчэ илэгү мэдэн-э гэжү бэй-э-бэн бүү магта
Хүчү чидал магу гэжү хүмүн-и бүү басу

7. “Шүхэрч Буниа” зохиолын Буниагийн дүрийг тодруулахад орчин нөхцөл ямар үүрэгтэй байсан гэж бодож байна вэ? Дүгнэн бичнэ үү. Үгийн тоо 40-50, 5 оноо

Б хувилбар

7-Р АНГИЙН АНГИ ДЭВШИХ ШАЛГАЛТЫН ЖИШИГ ДААЛГАВАР

Хугацаа: 40 минут

Нийт 20 оноо

Хуучин хүү

Хотын байдал шалдар булдар, цагийн улирал ороо бусгаа, хүмүүсийн амьдралд тус болох зар хааяа нэг цагаан хоолойгоор пар пар цангинана. Зуны аагим халуун нар эгц дээрээс нэвт шарж, олон наймаачны сэтгэлийг бухимдуулна. Нарантуул захаар хүмүүс холхино. Гутлын наймаачин Жамбал лангуун дээрээ суун, элдвийг ярих ба бас нэг наймаачин Намжил гэгч улс төр гэж худал үнэн ярина.

Хуучин хүү тэргээ чирсээр айсуй. Саравчтай малгай толгойдоо углан, урагдаж навтарсан эрээн цамцны энгэрийг задгай тавьж, хиртэж сайрсан бор тохойг гаргажээ. Нас хэдий залуу боловч хотод таних ойр дотны хүн үгүй. Өнчин балчир тул их гарын наймаачдын барааг цөөн явсаар олигтой аж амьдралын замыг нэгэнт алджээ.

Гэтэл хуучин хүүгийн тэрэг түрэгч нэг нөхөр эрдэм боловсролын үрийг амсаж эхэлсэн тэр өдрөөс эхлэн хөмөрсөн тогооны дотор гэрэл тусаж хэсэг хүмүүс сэргэв. Нарантуулаас гадна сургууль соёл байдгийг мэдэж, эрдэм сурч боловсрох тухай танин, шинэ зуунд бусадтай хамт алхах замыг нээв.

/“Хуучин хүү” сурагчийн зохиосон эх /

1. Эхээс хэрэг явдал болж байгаа газар, хүний үйл хөдлөлийг дүрслэн тоочсон хэсгийг олж бичээрэй. (2 оноо)
2. Зуны аагим халуун нар эгц дээрээс нэвт шарж, олон наймаачны сэтгэлийг бухимдуулна. Өгүүлбэрийн холбогдсон аргыг тодорхойлж, бүтцийг тодорхойл. 2 оноо
3. Хотын байдал шалдар булдар, цагийн улирал ороо бусгаа, хүмүүсийн амьдралд тус болох зар хааяа нэг цагаан хоолойгоор пар пар цангинана. Зуны аагим халуун нар эгц дээрээс нэвт шарж, олон наймаачны сэтгэлийг бухимдуулна. “ гэсэн эхийн хэсгээс дараах үгсийн аймгийн 2 жишээ ялган бичээрэй. (2 оноо)

Тэмдэг нэр:

Дуурайх үг:

4. Тодруулсан өгүүлбэрээс эсрэгцүүлэн холбох үгийг олж бичээд, солин найруулахад тохирох холбох үгийн жишээ 1-ийг бичнэ үү. 2 оноо

Ундэсний бичгээс кирилл рүү хөрвүүлэн бичээрэй. 5 оноо

5.

Ундэсний бичгээс кирилл рүү хөрвүүлэн бичээрэй. 5 оноо

6. “Цагаан сүүний домог” туурийн хатны дүрийг тодруулахад орчин нөхцөл ямар үүрэгтэй байгааг жишээ татан тайлбарлан бичээрэй. 5 оноо